

**I. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ МЭРГЭЖИЛТНИЙ
БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

1. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл.
2. Мэргэжлийн зэрэг горилогчийн маягтын бүрэн бөглөж, байгууллагын даргаар баталгаажуулсан маягт.
3. Холбогдох мэргэжлийн нийгэмлэг, холбооноос гаргасан тусгай шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулсан баримтууд.
4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлаггүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхний баталгаажсан хуулбар.
5. Мэргэжлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхний эх хувь
6. Нотариатаар баталгаажсан иргэний үнэмлэхний хувь
7. 3*4 хэмжээний зураг 2 хувь.
8. Бүртгэлийн хураамж 9000 төгрөг.

II. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ “НИЙТЛЭГ” ШАЛГУУР

Эмнэлгийн мэргэжилтэнд АХЛАХ, ТЭРГҮҮЛЭХ зэрэг олгоход дараах нийтлэг шалгуурыг баримтална.

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлаггүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.
- Мэргэжлээрээ **10** ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх.

Эмнэлгийн мэргэжилтэнд “ЗӨВЛӨХ” зэрэг олгоход дараах нийтлэг шалгуурыг баримтална.

- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлаггүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.
- Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх.
- 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

III. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ “ТУСГАЙ” ШАЛГУУР

1. Ахлах зэрэг горилж буй эмчийн шалгуур:

- Хавдар судлаач мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх.

2. Тэргүүлэх зэрэг горилж буй эмчийн шалгуур:

- Ахлах зэрэг хамгаалаад мэргэжлээрээ 5 жил ажилласан
- Ахлах зэрэг хамгаалсанаас хойш тасралтгүй үр бүтээлтэй, ажилласаныг тодорхойлсон байгууллагын удирдлага, өөрөөс ахлах зэрэг бүхий мэргэжилтэний/тасгийн эрхлэгч, удирдагч багш гм/ тодорхойлолтыг тус тус бүрдүүлнэ.

3. Зөвлөх зэрэг горилж буй эмчийн шалгуур:

- Боловсролын доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой.
- 3-р шатлалын хавдрын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан.
- Эрдэм шинжилгээ, судалгааны 10-с доошгүй бүтээлтэй байх.
- Гадаадын нарийн мэргэжлийн сургалтанд 2-с доошгүй жил хамрагдсан байх.

ХАВДАР СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ